



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/217

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын нэрэмжит шагналын зардалд 661 000 төгрөг, Хууль хүчний байгууллагын удирдлагуудтай зохион байгуулсан хэлэлцүүлгийн зардалд 618 000 төгрөг, аймгийн постуудын үйл ажиллагааг шалгаж ажиллаж буй алба хаагчдад амин дэм, хоол олгосон зардалд 358 000 төгрөг, Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын Байгаль орчны нөлөөллийн талаар ард иргэдэд зохион байгуулсан хэлэлцүүлгийн зардалд 767 800 төгрөг, Засаг дарга, орлогч дарга нар Мянгад, Зэрэг, Алтай сумдад ажилласан зардалд 990 100 төгрөг, бусад арга хэмжээний зардалд 632 700 төгрөг, Хүнсний дэлгүүрүүдэд нөөцийн мах тарааж буй ажилчдын халдвар хамгааллын хувцас хэрэгсэлийн зардалд 696 000 төгрөг, Тархвар судлалын 2 ажилтны утасны төлбөрт 98600 төгрөгийн зардлыг тус тус зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 4 822 200 төгрөг /Дөрвөн сая найман зуун хорин хоёр мянга хоёр зуун/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/217 Ch
20 1288